

2026 оны 6 сарын ... -ны өдөр

**УСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Усны тухай хуулийг шинэчлэн найруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй үзэл баримтлал”-ын “3.5.Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал. Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын хомсдолоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн”, “3.5.1.1.Усны салбарын бүтэц, зохион байгуулалт, хяналтын механизмыг боловсронгуй болгож, ашиглагч нь хамгаалах, хариуцлага хүлээх тогтолцоог бий болгож, хүн амын ундны ус хангамж, үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хүртээмжтэй, тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлнэ. 3.5.1.2.Усны үнэлэмжийг нэмэгдүүлэх, нөөцийг хамгаалах, өсгөх ажлыг санхүүжүүлэх механизмыг тодорхой болгох, улсын төсвийн хөрөнгөөр хийсэн усны эрэл, хайгуулын зардлыг эргэн төлүүлэх чиглэлээр эрх зүйн зохицуулалт хийнэ. 3.5.1.3.Газрын доорх усны нөөцийг шинэчлэн тогтоох усны эрэл, гидрогеологийн зураглалын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хийж нөөцийг бүртгэлжүүлж мэдээллийн сан, хяналт-шинжилгээний сүлжээ, судалгаа шинжилгээний байгууллагын чадавхийг бэхжүүлнэ. 3.5.1.4.Газрын доорх цэнгэг усны томоохон ордууд, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах, цэвэр усны нөөц бүхий томоохон нуурын сав газарт аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах замаар усны нөөцийг хамгаална. 3.5.1.5.Усны сав газрын менежментийн тогтолцоог нэвтрүүлж, тухайн сав газрын хэмжээнд экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр ашиглах боломжтой гадаргын болон газрын доорх усны нөөцийг тогтоож, ашиглалтыг тогтоосон хэмжээнд нь хатуу барина. Аль нэг ашиглагчид давуу эрх олгохгүй байх эрх зүйн зохицуулалт бий болгоно. 3.5.1.6.Хангай, Хэнтийн нурууны усны эх, Хөвсгөл нуур орчмын газрыг Үндэсний парк байгуулах замаар улсын нөөцөд авч, уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглоно. 3.5.1.7.Гадаргын усны ашиглалтыг сайжруулах үүднээс

томоохон гол, мөрөнд урсацын тохируулга хийж, бороо, цас, мөсний усыг хуримтлуулж нөөцлөх усан санг ууршил багатай, эрчим хүчний нөөц ихтэй бүс нутагт байгуулж, говь, тал хээрийн ууршил ихтэй бүсэд усыг нөөцлөх, дамжуулах далд систем барьж байгуулна. 3.5.1.8. Усны хэмнэлттэй хэрэглээ, технологийг нэвтрүүлэх, ус, эрчим хүчний ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх, газар тариалангийн усалгаанд газрын доорх усыг ашиглах болон хүнсний бус үйлдвэрлэлийн салбарт ундны цэвэр усыг ашиглах явдлыг хязгаарлах, хаягдал усыг дэвшилтэт технологиор цэвэршүүлэх, цэвэршүүлсэн хаягдал ус болон саарал усыг дахин ашиглахыг бодлогоор дэмжинэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050”-ын хүрээнд 2021-2030 онд Говийн бүс рүү ус дамжуулах хоолой барьж байгуулна, Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ, Дотоодын цэргийн хамгаалалтад шилжээгүй дулааны цахилгаан станц, зарим аймгийн төв болон хүн амын суурьшил, иргэдийн хөдөлгөөний нягтаршил ихтэй сумдын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг хамгаалалтад авч, иргэдийн аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилтыг тус тус дэвшүүлсэн.

1.2. Практик хэрэгцээ шаардлага:

Улсын хэмжээнд газрын доорх усны нөөцийн тархалт жигд бус, чанар, найрлага нь байгалийн бүс, бүслүүр, ус агуулах чулуулгийн тогтоц, найрлагаас хамаарч өөр өөр байна. Гадаргын усны нөөцийн 70% нь Алтай, Хангай, Хэнтий нуруу, Хөвсгөлийн уулс, Их Хянганы нуруу зэрэг уул нуруудын өндөрлөг хэсэгт нийт нутаг дэвсгэрийн 30% орчим эзлэх талбайд бүрдэнэ. Монгол орны нутаг дэвсгэрт олон жилийн дунджаар 608.4 сая м³ усны нөөц бүрэлдэн бий болдог байсан бол хамгийн сүүлд 2016 онд хийсэн судалгааны үр дүнгээр 564.8 сая м³ болж багассан байна. Энэ нь дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас мөнх цас, мөсөн голын эдлэх талбай багасч, нимгэрсэнтэй холбоотой байна. Уг судалгааны дүнгээр нуурын ус 500.0 сая м³, мөстөл, мөсөн гол, цас 19.4 сая м³, гол мөрөн 34.6 сая м³, газрын доорх ус 10.8 сая м³ гэж гарчээ. Усны нөөцийн 6.1% гол мөрөнд, 88.5% нь нуурт, 3.4% нь мөстөл, мөсөн голд, 1.9% нь газрын доорх усанд байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан жилд дунджаар (2016-2020 оны дундаж) 261 гол мөрөн, 258 нуур, тойром, 623 булаг шанд, рашаан хатаж ширгэдэг ажээ. Сүүлийн 3 жилд гол горхины 7.5%, булаг шандын 1.7% нь хатаж ширгэсэн байна.

2012 онд Усны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан боловч газрын доорх усны зохицуулалт тодорхой бус, газрын доорх устай холбоотой харилцааг зөв зохистой шийдвэрлэх эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй бөгөөд энэ нь газрын доорх усны зохисгүй, хэт төвлөрсөн хэрэглээг нэмэгдүүлэхэд хүргэж байна. Монгол Улс усны нөөцийн хувьд жигд бус тархалттай бөгөөд нийт усны нөөцийн дийлэнх хэсэг нь гадаргын усанд ногдож, хүн ам, үйлдвэрлэл, уул уурхайн төвлөрөл өндөр бүс нутагт усны хүртээмж харьцангуй хязгаарлагдмал байна. Нөгөө талаас усны нийт хэрэглээний 80 орчим хувийг газрын доорх уснаас хангаж байгаа боловч энэхүү нөөц нь улсын нийт усны нөөцийн ердөө 1.9 хувийг бүрдүүлдэг. Иймд усны нөөцийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт, нэгдсэн менежментийг урт хугацаанд хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг шинэ шатанд гаргах шаардлага үүсээд байна.

Одоогийн хууль тогтоомжид усны нөөцийн стратегийн үнэлгээ, усны нөөцийн урт хугацааны төлөвлөлт, усны экосистемийн үйлчилгээний үнэлэмж, усны нөөцийн хамгаалалтын эдийн засгийн механизм зэрэг орчин үеийн зохицуулалтууд хангалттай тусгагдаагүй байгаа нь усны нөөцийн тогтвортой байдлыг хангахад хүндрэл учруулж байна.

Монгол Улсын хэмжээнд усны нөөцийн нарийвчилсан судалгаа, эрэл-хайгуулын ажил бүс нутаг бүрд жигд хийгдээгүй бөгөөд усны нөөцийн мэдээллийн сангийн бүрдүүлэлт, шинэчлэл хангалтгүй байна. Уур амьсгалын өөрчлөлт, хүн амын өсөлт, үйлдвэрлэл, уул уурхайн хэрэглээ нэмэгдэхийн хэрээр усны нөөцийн эх үүсвэрийг шинээр илрүүлэх, нөөцийг тогтоох, стратегийн ач холбогдол бүхий усны нөөцийг тодорхойлох хэрэгцээ нэмэгдэж байна.

Гэвч усны нөөцийн хайгуул, судалгааны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, санхүүжилтийн эх үүсвэр, мэдээлэл ашиглалт, мэдээллийн нэгдсэн тогтолцоотой холбоотой зохицуулалт хангалтгүй байгаа нь усны нөөцийн шинжлэх ухаанд суурилсан төлөвлөлт, удирдлагыг хэрэгжүүлэхэд саад болж байна. Иймд усны нөөцийн хайгуул, судалгааг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дэмжих, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн үндсийг шинэчлэх шаардлагатай байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр Монгол Улсад ган, цөлжилт, гол мөрөн, нуур, булаг шандын ширгэлт нэмэгдэж усны нөөцийн ихээр багасч байна. Усны хэрэглээ өсөн нэмэгдэж байгаа хэдий ч усны нөөцийн нөхөн сэргэх чадавх буурч байгаа нь усны хомсдолыг эрчимжүүлэх эрсдэлийг бий болгосоор байна.

Ялангуяа томоохон хот суурин газар, уул уурхайн бүс нутаг болон говийн бүсэд усны эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр алдагдах хандлага ажиглагдаж байгаа бөгөөд усны нөөцийг хамгаалах, дахин ашиглах, хуримтлуулах, усны удирдлага, зохион байгуулалтын чиглэлийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага үүсээд байна.

Ус нь хүн амын эрүүл мэнд, хүнсний үйлдвэрлэл, эрчим хүч, уул уурхай, үйлдвэрлэл, хот байгуулалт зэрэг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн суурь нөөц бөгөөд үндэсний аюулгүй байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Усны нөөцийн хомсдол, чанарын доройтол, хүртээмжийн бууралт нь эдийн засгийн өсөлт саарах, хүн амын амьдрах орчин доройтох, бүс нутгийн хөгжлийн тэнцвэр алдагдах, улмаар үндэсний аюулгүй байдалд эрсдэл учруулах нөхцөл бүрдүүлж болзошгүй байна.

Иймд стратегийн ач холбогдол бүхий усны нөөцийг тодорхойлох, хамгаалах, усны аюулгүй байдлыг хангах үндэсний тогтолцоог бүрдүүлэх, усны нөөцийн ашиглалт, хамгаалалтыг үндэсний аюулгүй байдлын бодлого, төлөвлөлттэй уялдуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага бий болоод байна.

Усны нөөц нь үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн хөгжил, хүн амын амьжиргаа, экосистемийн тогтвортой байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий үнэт баялаг мөн. Гэвч усны нөөцийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, зохистой ашиглалтыг дэмжих өнөөгийн эрх зүйн болон эдийн засгийн механизм нь усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, дахин ашиглах, хэмнэлттэй хэрэглэх зорилтыг бүрэн хангаж чадахгүй байна.

Тухайлбал, ус ашигласны, ус бохирдуулсны болон усны нөөц хомсдуулсны төлбөрийн хувь хэмжээ нь усны бодит үнэ цэн, нөөцийн хомсдолын түвшин, экосистемийн үйлчилгээний үнэлэмж, усны эх үүсвэрийг хамгаалах, нөхөн сэргээхэд шаардагдах зардлыг хангалттай тусгаж чадахгүй байна. Нөгөө талаас усны хэрэглээг бууруулах, ус хэмнэх технологи нэвтрүүлэх, усыг дахин ашиглах, усны нөөцийг хамгаалах чиглэлээр санаачилга гаргаж буй ус ашиглагчдыг эдийн засгийн аргаар дэмжих, урамшуулах тогтолцоо сул байна.

Үүний улмаас усны нөөцийг үр ашиггүй ашиглах, хэт их олборлох, бохирдуулах, дахин ашиглалтыг үл ойшоох хандлага хэвээр байгаа бөгөөд усны нөөцийн тогтвортой менежментийг хангахад хүндрэл учруулж байна. Иймд усны үнэ цэн, нөөцийн хомсдол, ашиглалтын үр ашигтай уялдсан эдийн засгийн зохицуулалтыг боловсронгуй болгож, усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хэмнэлттэй болон дахин ашиглах үйл ажиллагааг эдийн засгийн хөшүүргээр дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага үүсээд байна.

Үүний хүрээнд Усны тухай хуульд газрын доорх ус ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын хоорондын харилцааг тодорхой зохицуулах, түүнчлэн хяналт-шинжилгээ, үнэлгээ болон хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох шаардлага тулгамдсан асуудал болж байна.

Мөн уул уурхай, аж үйлдвэр эрчимтэй хөгжиж буй өнөөгийн нөхцөлд газрын доорх цэнгэг усны нөөцийг хамгаалах, хамгаалалтын дэглэм тогтоох, ашиглагдаж дууссан болон орхигдсон цооногийг стандартын дагуу битүүмжлэх, нөхөн сэргээх эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тогтоох хэрэгцээ бий болоод байна.

Түүнчлэн усны ашиглалт, хэрэглээний эрэмбийг тодорхойлон иргэдийн унд, ахуйн хэрэгцээний усыг нэн тэргүүнд хангах зарчмыг хуульчлах, гадаргын усны үр ашигтай ашиглалтыг нэмэгдүүлэх бодлогын зохицуулалтыг дэмжих, усны нөөцийн хомсдлын түвшнийг үнэлэх, тогтоох, хянах эрх зүйн орчныг бүрдүүлэх нийгэм, эдийн засгийн шаардлага үүсээд байна.

Үүнтэй уялдуулан усны удирдлага, зохион байгуулалтын оновчтой бүтцийг тодорхойлох, усны нөөцийн нэгдсэн менежментийг хангах зорилгоор төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг давхардал, хийдэлгүй болгон дахин инженерчлэх шаардлага мөн адил тулгамдаж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь усны нөөц болон түүний сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, усны харилцаанд оролцогчдын эрх зүйн байдлыг тодорхойлох, усны нөөцийн нэгдмэл удирдлагыг хангахтай холбоотой харилцааг цогц байдлаар зохицуулахад оршино.

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд усны харилцаанд оролцогч талуудын эрх, үүрэг, оролцоо, түүнчлэн усны нөөцийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийн хуваарилалтыг энэ хуулиар нарийвчлан зохицуулна.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, 25.1.3-т заасан шаардлагын дагуу шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөл нь нийт 8 бүлэгтэй байх бөгөөд дараах зохицуулалтыг тусгана.
Үүнд:

Нэгдүгээр бүлэгт – Хуулийн нийтлэг үндэслэл
Хоёрдугаар бүлэгт – Усны нөөц, аюулгүй байдал
Гуравдугаар бүлэгт – Усны харилцаанд талаарх төрийн болон бусад байгууллагын эрх, үүрэг
Дөрөвдүгээр бүлэгт – Усны нөөцийн хамгаалалт
Тавдугаар бүлэгт – Ус ашиглалт
Зургаадугаар бүлэгт – Усны нөөцийг нөхөн сэргээх, усны төлбөр
Долоодугаар бүлэгт – Усны хяналт-шинжилгээ, аудит аюулгүй байдал
Наймдугаар бүлэгт – Усны маргаан шийдвэрлэх ажиллагаа болон хуулийн хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал.

3.1.Нийгмийн үр дагавар

Хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжсэнээр иргэдийн аюулгүй, хүртээмжтэй ундны ус хэрэглэх эрхийн хамгаалалт сайжирч, усны нөөцийн хомсдол, бохирдлоос үүдэлтэй эрүүл мэндийн эрсдэл буурах эерэг нөхцөл бүрдэнэ. Мөн усны мэдээллийн ил тод байдал, олон нийтийн оролцоо нэмэгдсэнээр орон нутгийн иргэд шийдвэр гаргах үйл явцад оролцох боломж өргөжинө.

Усны эрх зүйн боловсрол, олон нийтийн мэдээлэл, сурталчилгааны тогтолцоог үе шаттай хөгжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагын усны эрх, үүрэг, хариуцлагын ойлголтыг нэмэгдүүлнэ. Түүнчлэн шинэ зохицуулалтад дасан зохицох боломж олгох зорилгоор шилжилтийн үеийн хугацааг тогтоож, зөвшөөрөл, төлбөр, мониторинг, ус хэмнэлтийн шаардлагыг үе шаттай хэрэгжүүлнэ.

Сав газрын нэгдсэн менежментийг бэхжүүлэх хүрээнд орон нутгийн иргэд, иргэний нийгэм, ус ашиглагчдын оролцоог нэмэгдүүлж, хамтын удирдлагын механизмыг хөгжүүлнэ.

Мөн усны мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор усны нэгдсэн дата сан, цахим мэдээллийн систем, цахим хяналтын тогтолцоог хөгжүүлж, төрийн байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоог сайжруулна.

3.2. Эдийн засгийн үр дагавар

Усны нөөцийг эдийн засгийн үнэлгээнд суурилсан байдлаар ашиглах нөхцөл бүрдэж, усны үр ашиггүй хэрэглээ буурч, дахин ашиглалт нэмэгдэн, ус хэмнэлтийн технологийн хэрэглээ өргөжих эерэг нөлөө үзүүлнэ.

Ус ашигласны төлбөр, бохирдуулсны болон хомсдуулсны нөхөн төлбөр, хяналт-шинжилгээ болон цэвэршүүлэлтийн шаардлагыг үе шаттай хэрэгжүүлэх замаар усны нөөцийн үр ашигтай, хариуцлагатай хэрэглээг төлөвшүүлнэ.

Усны мэдээллийн нэгдсэн сан, лаборатори, мониторинг болон сав газрын менежментийн тогтолцоог хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг улсын төсөв болон олон улсын санхүүжилтийн эх үүсвэрээр бүрдүүлнэ.

Мөн ус хэмнэх, дахин ашиглах технологи нэвтрүүлж буй иргэн, аж ахуйн нэгжийг татварын хөнгөлөлт, санхүүгийн дэмжлэгийн бодлогоор урамшуулж, усны үр ашигтай хэрэглээг дэмжих эдийн засгийн хөшүүргийг бүрдүүлнэ.

Усны төлбөрийн тогтолцоог эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан үе шаттайгаар шинэчлэн хэрэгжүүлж, усны бодит үнэ цэнд суурилсан зарчимд шилжинэ.

Түүнчлэн стратегийн салбарууд болох уул уурхай, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт шинэ зохицуулалтыг үе шаттай нэвтрүүлж, дасан зохицох шилжилтийн зохицуулалтыг хэрэгжүүлснээр эдийн засгийн гэнэтийн дарамт, сөрөг нөлөөллийг бууруулна.

Ус хангамж, цэвэршүүлэх байгууламж, дахин ашиглалтын дэд бүтцийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөгжүүлж, олон улсын санхүүгийн байгууллагуудын дэмжлэг, ногоон хөрөнгө оруулалтыг татах бодлогыг идэвхжүүлнэ.

3.3. Хууль зүйн үр дагавар

Хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар усны нөөцийн удирдлага, сав газрын менежмент, ус ашиглалтын зөвшөөрөл, хяналт-шинжилгээ, мэдээллийн тогтолцоо болон усны аюулгүй байдлын зохицуулалт нэгдмэл, уялдаа холбоотой эрх зүйн орчинд шилжих нөхцөл бүрдэнэ. Үүний үр дүнд төрийн байгууллагуудын чиг үүргийн давхардал буурч, бүрэн эрхийн хуваарилалт тодорхой болж, сав газрын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо бэхжинэ.

Мөн усны аудит, усны нэгдсэн мэдээллийн сан, экологийн урсац, цахим мониторинг, усны эрсдэлийн удирдлага зэрэг орчин үеийн институцийн зохицуулалтууд хуульчлагдсанаар усны нөөцийг шинжлэх ухаанд суурилсан удирдах эрх зүйн үндэс бүрдэнэ.

Усны харилцаатай холбоотой бусад холбогдох хууль тогтоомж хоорондын уялдаа холбоо сайжрах нөхцөлийг бүрдүүлж, давхардал болон зөрчлийг үе шаттайгаар арилгана.

Мөн холбогдох дүрэм, журам, стандарт, аргачлал, техникийн зохицуулалтыг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийн нэгдмэл суурь нөхцөлийг хангана. Иймд хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд үе шаттай хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, оролцогч талуудын эрх зүйн статусыг тодорхой болгох, усны маргаан шийдвэрлэх тусгай процедур нэвтрүүлэх, дагалдах хууль тогтоомжид шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг хийнэ.

Хуулийн хэрэгжилт нь институцийн чадавх, төсөв, хүний нөөц, олон нийтийн ойлголт, салбар хоорондын уялдаа болон дагалдах эрх зүйн орчны бүрдэлттэй салшгүй холбоотой тул хэрэгжилтийг үе шаттай, шинжлэх ухаанд суурилсан, олон талт оролцоонд тулгуурлан зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн талаар.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай нийцсэн байх бөгөөд
.....
тухай хууль болон бусад холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай зэрэг хуулийн төслийг тус тус боловсруулна.

---o0o---